

БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Эрүүл мэндийн газар

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1	<p>“Алсын хараа 2050” бодлогын баримт тусгагдсан зорилт, арга хэмжээ</p> <p>2.2.16.Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.</p>						
1.1.1	<p>Мэргэжлийн байгууллагуудтай хамтран (ЭХЭМҮТ, ГССҮТ) 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг бууруулах, хүүхдийг осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах</p>		<p>-1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин -Эцэг, эх, асран хамгаалагч нарт зохион байгуулсан сургалтын тоо</p>	<p>-1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-1.0 -Эцэг, эх, асран хамгаалагч нарт зохион байгуулсан сургалтын тоо-2</p>	<p>-1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-0.5 -Эцэг, эх, асран хамгаалагч нарт зохион байгуулсан сургалтын тоо-4</p>	<p>Эрүүл мэндийн статистик мэдээгээр 2023 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 0.2 байгаа нь улсын дунджаас 2.4 промилээр бага байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан тодорхойлох магадлан хэлэлцэх хурлыг 3 удаа зохион байгуулж, Эрүүл мэндийн байгууллагуудад эх барих, эмэгтэйчүүд болон хүүхдийн эмчийн зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанаас 7 хоног бүрийн Лхагва гарагт хүүхдийн эндэгдлээс сэргийлэх чиглэлээр цахим хурал, сургалт мэдээллийг тогтмол зохион байгуулж байна.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эх барих эмэгтэйчүүдийн тасагтай хамтран нярайн эндэгдлийн тохиолдол бүртгэгдсэн Рашаант, Могод, Бүрэгхангай сумдад “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж” сэдэвт онол болон дадлага хосолсон сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үеэр 30 эцэг эхэд хүүхдийн эндэгдлээс сэргийлэх чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгсөн.</p> <p>ЭМХТ-тэй хамтран “Хүүхдийн өвчний цогц менежмент, хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж сэдвээр сургалт”-ыг зохион байгуулж, 27 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан чадавхжуулсан.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагуудын Эх баригч бага эмч, Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, Нийгмийн эрүүл мэндийн ажилтан нарт "Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 58 эмч, мэргэжилтэн болон олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан.</p>	90

						Хүүхдийг осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 төрлийн зөвлөмж бүхий мэдээллийг цахим хуудсанд байршуулж, 8 төрлийн 1800 гаруй тараах материалыг иргэдэд тарааж сурталчилсан байна.	
1.2	МУ-ын таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.2.1	Зүрх судас, осол гэмтлийн шалтгаант өвчлөл, эндэгдэлд тандалт, судалгаа хийж, хэрэгцээнд суурилсан сургалт сурталчилгаа зохион байгуулах		- Судалгааны дүгнэлт - Зохион байгуулсан сургалтын тоо	-Судалгааны дүгнэлт-0 -Зохион байгуулсан сургалтын тоо-2	-Судалгааны дүгнэлт -Зохион байгуулсан сургалтын тоо-4	Хүн амын дунд зонхилон тохиолдох цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 40-64 насны 15246 хүний 14152 буюу 92,8 хувийг хамруулан, зүрх судасны эмгэгээс урьдчилан сэргийлж, зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан. “Эрсдэлгүй-эрүүл орчныг хамтдаа” уриан дор авто машингүй өдөр, осол гэмтлээс сэргийлэх сарын аянд 8 байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран 465 иргэнд сургалт, сурталчилгааг зохион байгуулсан. Аймгийн хэмжээний 16 сумын Эрүүл мэндийн төвүүдийн осол гэмтэл, унаж бэртэхээс урдчилан сэргийлэх 18 мэдээллийг цахим хуудсанд байршуулж, 451 хүн татаж авсан, 389 хүнд мэдээлэл таалагдсан, 2521 хүн үзсэн байна	90
1.2.2	Булган сумын ЕБС-ийн 5-6-р ангийн сурагчдын эрүүл мэндийн мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгаа хийж, дүгнэлт гаргах		-Сурагчдын эрүүл мэндийн боловсролын түвшин /хувиар/ -Судалгааны тайлан	-Сурагчдын эрүүл мэндийн боловсролын түвшингийн суурь судалгаа хийгдээгүй.	-Сурагчдын эрүүл мэндийн түвшинг тодорхойлсон байна. -Эрүүл мэндийн хичээлийн чанарт дүгнэлт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.	Боловсрол шинжлэх ухааны газар, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран 4-11 дүгээр ангийн сурагчдаас санамсаргүй түүврийн аргаар нийт сурагчдын 40%-ийг түүвэрлэн эрүүл мэндийн хичээлийн 6 агуулгын хүрээнд суралцагчдын мэдлэг чадварын үнэлгээг хийлээ. Үнэлгээгээр сурагчдын эрүүл мэндийн мэдлэгийн түвшин 60%-тай гарсан байна. Энэ нь улс, аймгийн дунджаас 5%-иар дээгүүр үнэлэгдсэн. Үнэлгээний сэдэв тус бүрээр үнэлэхэд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, аюулгүй байдал ба анхны тусламж сэдвүүдийн хүрээнд анхаарах шаардлагатай буюу улсын дундажаас 2.23% доогуур үнэлэгдсэн байна. Эрүүл мэндийн боловсролыг заадаг биологи, биеийн тамирын багш нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.	90
1.2.3	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг түшиглэн шат дараалсан сургалт сурталчилгааг өргөжүүлэх		-Зохион байгуулсан сургалтын тоо, төрөл -Хамрагдсан иргэдийн тоо	-Зохион байгуулсан сургалтын тоо, төрөл-2 -Хамрагдсан иргэдийн тоо-95	-Зохион байгуулсан сургалтын тоо, төрөл-4 -Хамрагдсан иргэдийн тоо-100	Аймгийн хэмжээнд олон нийтийн эрүүл мэндийн 95 ажилтныг бэлтгэж, сум, өрхийн ЭМТ-үүд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх 32 удаагийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан. НЭМҮТ, МУЗН, НҮБ-ын Хүүхдийн сан-тай хамтран 2 удаа олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг сургаж, дадлагажуулсан. "Олон нийтэд түшиглэсэн нялх, бага	90

						насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө” сэдэвт сургалтанд анхан шатны ЭМБ-уудын 54 эмч, мэргэжилтэн болон олон нийтийн эрүүл мэндийн ажилтантай хамтран сургалт зохион байгуулсан.	
1.2.4	Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд 18-аас дээш насны иргэдийг хамруулах		Илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь	Илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь-11.6%	Илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь-15%	Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношлогоонд 18-с дээш насны 10080 хүнийг хамруулж, өмнө оныхоос 7818-аар нэмэгдэж, тухайн насны хүн амын 24,6 хувийг хамруулсан. Аймгийн ЗД-ын нэрэмжит нарийн мэргэжлийн эмчийн үзлэг "Хүрч үйлчилье" арга хэмжээ, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг 15 сум, 1 тосгонд зохион байгуулж, нийт 25161 иргэн буюу 41,2 хувийг хамруулсан. Үзлэг, оношлогоогоор дээд шатлалын эмнэлэгт 51 иргэнийг онош тодруулахаар, 761 иргэнд хавдрын сэжигтэй, хавдрын урьдал, үүсгэвэр, уйланхай, ургацаг, чулуу, үрэвсэл зэрэг өвчлөлийн сэжигтэй тохиолдол илрүүлж, дээд шатлалын эмнэлэгт илгээсэн. Өвчлөл илэрсэн иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгч, их эмчийн хяналтад шилжүүлээ. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн өвчлөл хоол болосруулах замын эмгэг, зүрх судасны эмгэг, шээс бэлгийн тогтолцооны эмгэгүүд зонхилон тохиолдож байна. Оны эхний 11 сарын статистик мэдээгээр хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдсон 183 иргэний 40 хувийг эрт үед нь илрүүлэн эмчилгээнд хамруулсан байна.	100
1.3	МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.3.1	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх		Арга хэмжээ тус бүрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	5 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт тус бүр 70 хувьтай байна.	8 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна.	ЭМС-ын тушаалаар батлагдсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 8 арга хэмжээний төлөвлөгөөг 97.1%-тай хэрэгжүүлэн ажилласан.	100
1.3.1.1	“Эрүүл идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	70%	80%	Иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, бие бялдраа чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх санал, санаачлага өрнүүлэх "Энэ жилдээ -Эрүүл жиндээ", "Эерэг хандлага - Эрүүл нийгэм", "Цаг гаргая" аяныг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Уг аянд эрүүл мэндийн салбарын 20, бусад төрийн байгууллага, аж ахуй нэгжийн 6 байгууллагын давхардсан	100

						<p>тоогоор 742 ажилтан албан хаагч, иргэд хамрагдсан. Аймгийн хэмжээнд фитнес клуб 7, мэргэжлийн спорт холбоод 12, мэргэжлийн спорт клуб 7, чийрэгжүүлэх 14 танхим дасгал хөдөлгөөний болон эрүүл зөв хооллолты зөвлөгөө зөвлөмжийг давхардсан 9483 иргэд өгч ажилласан байна</p> <p>Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх өдөрлөг, уулзалт хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил 7, нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд 16, эмч, эмнэлгийн мэргэжилтний сургалт 17, нэрэмжит сарын аян 11, уралдаан тэмцээн 8-ыг тус тус зохион байгуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай.</p>	
1.3.1.2	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	70%	80%	<p>Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийг Аймгийн Засаг даргын 2023 оны А/199 дугаар захирамжаар 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.</p> <p>ЭМБ-уудын эрт илрүүлэг үзлэгт 0-5 насны 634 хүүхдийг хамруулж, өссөн дүнгээр 3847 болж нийт хүүхдийн 74,6 хувь, 6-17 насны 4532 хүүхдийг хамруулж, өссөн дүнгээр 10478 болж, хамрагдвал зохих хүүхдийн 77,7 хувийг хамруулсан</p> <p>“Эх, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах нь” сэдвээр онол, дадлага хосолсон сургалт, “Хүүхдийн өвчний цогц менежмент, яаралтай тусламжийн эрэмбэлэн ангилалт” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 52 эмч, эх баригчдыг хамруулсан.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажлын байрны солилцох сургалтад 1 их эмч, 3 эх баригчийг хамруулсан байна. “Олон улсын эх баригч”-ийн өдрийг угтаж аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн нийт 22 эх баригч мэргэжилтнүүд Хялганат тосгоны ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад мэргэжил сурталчлах “Миний мэргэжил сайхан “өдөрлөг зохион байгуулж, төгсөх ангийн 60 гаруй сурагчдыг хамруулсан.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эх барих эмэгтэйчүүдийн тасагтай хамтран нярайн эндэгдлийн тохиолдол бүртгэгдсэн Рашаант, Могод, Бүрэгхангай сумдад “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж” сэдэвт онол болон дадлага хосолсон сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үеэр 30 эцэг эхэд хүүхдийн эндэгдлээс сэргийлэх чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгсөн.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагуудын Эх баригч бага эмч, Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, Нийгмийн эрүүл мэндийн</p>	90

						ажилтан нарт "Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө" сэдэвт сургалтыг зохион байгуулж байна. Сургалтанд нийт 58 эмч, мэргэжилтэн, сайн дурын идэвхитэнүүдийг хамруулсан. Эрүүл мэндийн байгууллагууд нь Эх барих эмэгтэйчүүд болон нярайн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай 409.830.000	
1.3.1.3	"Хавдрын эсрэг" арга хэмжээг хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	70%	80%	Аймгийн хэмжээнд хорт хавдартай 577 иргэн эмчийн хяналтад байгаа ба тэдний ар, гэр, асран халамжлагч 124 иргэнд "Хавдрын өвчний сэтгэл зүй, сэтгэл засах болон асаргаа сувилгаа"-ны талаар, үйлчлүүлэхээр ирсэн иргэдэд зөвлөгөө, мэдээллийг тухай бүрт хийж 15 төрлийн хавдрын 1720ш гарын авлагаар хангасан. Оны эхний 11 сарын статистик мэдээгээр хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдсон 183 иргэний 40 хувийг эрт үед нь илрүүлэн эмчилгээнд хамруулсан байна. Хавдар үүсгэгч эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хоол хүнс, согтууруулах ундаа, бусад хүчин зүйлсийн чиглэлээр 10 удаагийн сургалтыг зохион байгуулж 646 иргэнийг хамруулсан. Булган хангай МСҮТ, Спортын дунд сургууль болон бусад ЕБС-иудын 6-12 дугаар ангийн сурагчдад "Хорт зуршил гэж юу вэ?", "Архи согтууруулах ундаа, электон тамхи, дэлгэцийн донтолт" зэрэг сэдвүүдээр 10 удаагийн сургалтыг зохион байгуулж, 869 сурагчдыг хамруулсан. "Тамхины эсрэг хувьсгал" хөдөлгөөнийг тогтмол зохион байгуулж "Тамхины хор хөнөөл" сэдэвт 38 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 7105 иргэнийг хамруулсан. Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 97.0 хувьтай байна.	100
1.3.1.4	"Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	70%	80%	"Цэвэр орчин-Цэмцгэр Булган" "Шарилжгүй Булган" аяны хүрээнд Хөвсгөл-Булган-Эрдэнэт чиглэлийн хот хоорондын 85 км улсын чанартай авто замын цэвэрлэгээг жилдээ 2 удаа, хөл ургамлын цэвэрлэгээнд 58 төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгжүүд хуваарьт газраа цэвэрлэсэн. УЦУОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лаборатори нарийн ширхэглэлт тоосонцорын агууламжийг "purple air" багажаар шууд хэмжлийн аргаар тодорхойлоход агаарын бохирдлыг MNS 4585:2016 стандарттай харьцуулахад хүйтний улирал буюу 1-2, 11 дугаар саруудад 1,2-3,3 дахин давсан үзүүлэлттэй бусад саруудад бохирдол хэвийн хэмжээнд байна.	100

						Аймгийн төвийн ногоон байгууламжийн 49192м2 талбайд 8 төрлийн 13000 ширхэг цэцгийн үрсэлгээг суулгаж, 2720м2 талбайг зүлэгжүүлэн төв цэнгэлдэх хүрээлэнгийн 12500м2 зүлгийн арчилгаа, хамгаалалтыг гүйцэтгэж 15084 ширхэг мод бутыг тарьж арчлан хамгаалсанаар эрүүл ногоон орчныг бүрдүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 100.0 хувьтай байна.	
1.3.1.5	“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	70%	80%	Хутаг-Өндөр суманд зохион байгуулсан эрэгтэйчүүдийн эмчийн үзлэг, эрт илрүүлэг, цэргийн насны эрчүүдийн үзлэгт нөхөн үржихүйн насны 2418 эрэгтэйчүүдийг хамруулж, эрүүл эцэг, эхээс эрүүл хүүхэд төрүүлэх талаар эмчийн зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа. Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт сурталчилгаанд 3698 иргэнийг хамруулсан. Эрт илрүүлэг үзлэгт 18 –аас дээш насны 9205 эрчүүд үзлэгт хамруулсан нь нийт үзлэгийн 47,2%-ийг эзлэж байна. “Эрчүүдийн үнэт зүйлс, бахархан дуураих үйлс” арга хэмжээг Булган аймгийн ХЖТ-т зохион байгуулж, 250 эрэгтэй төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулсан. Өрхийн эрүүл мэндийн төвд “Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалахад эмэгтэйчүүдийн оролцоо” арга хэмжээг зохион байгуулж, эрүүл мэндийн даатгалыг үл хамааран, оношилгоо шинжилгээ авч, нийт 56 эрчүүдийг хамруулсан. “Гүзээгүй Монгол эр хүн” аяны хүрээнд цахимаар зөвлөмж, мэдээлэл түгээж, төр, хувийн хэвшлийн 227 албан хаагчдыг хамруулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100.0 хувьтай байна.	100
1.3.1.6	“Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	80%	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний хүрээнд 15-аас дээш насны 28337 иргэнийг хамруулж, хамралт 63.3 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 8.2%-иар өссөн. Элэгний В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд 1954 хүн хамруулсны 230 буюу 11,7 хувьд вирус илэрсэн байна. Жирэмсний эрт үеийн хяналтад хамрагдсан 510 эхийг элэгний В, С вирус, ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 100% хамруулан, В вирустэй -12, С вирустэй 1 эхийг илрүүлсэн. 2023 онд В вирустэй 12 эхээс төрсөн 12 нярайд В вирусийн иммуноглобулиныг, вакцины хамт хийж, дархлаажуулсан байна. Эрүүл мэндийн 65 ажилтаны В гепатитын дархлаажуулалтын тогтоцыг тодорхойлон дархлал тогтоц 10 ОУН-с дүүш үзүүлэлттэй 20 ЭМА-г В гепатитын дархлаажуулалтанд хамруулав. В вирусын халдвараас	100

					сэргийлэх сайн дурын дархлаажуулалтад 150 иргэнийг хамруулсан. Элэгний С, В вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээнд 18 хүнийг хамруулан, 12 хүн нь вирусийн эсэрг эмчилгээнд хамрагдаад байна. Аймгийн хэмжээнд нийт 248 хүн “В” нарийн мэргэжлийн эмчийн хяналтад вирусийн эмчилгээнд хийлгэж байна. Хэрэгжилт 100.0 хувьтай байна.		
1.3.1.7	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	80%	Аймгийн хэмжээнд цочмог халдварт өвчний 238 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 38,6 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс тохиолдол 2917 буюу 470,8 промиллоор буурсан байна. Аймгийн хэмжээнд томуу томуу төст өвчний хөдлөл зүйд 7 хоног тутам харуулдан тандаж, эрсдлийн үнэлгээг тогтмол хийж, халдварт өвчний эрт сэрэмжүүлэх хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэхэд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж, дадлагажуулах, тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэх чадвар эзэмшүүлэх чиглэлээр 3 удаагийн танхимын 6 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, нийт 210 гаруй эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Болзошгүй гамшиг ослоос сэргийлэх дадлага сургуулилалтыг аймгийн ОБГ, бусад салбар нэгжүүдтэй хамтран 2 удаа зохион байгуулж, 100 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамрууллаа. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын 3 сарын нөөцийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд заавал хийх дархлаажуулалтын хамралт 10 сарын байдлаар 95,4 хувьтай байна. Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх бэлэн байдлыг 85% хангаж, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.	100
1.3.1.8	“Орчны эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	80%	ЭМБ-ууд эмнэлгийн гаралтай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх чиглэлээр дотоод сургалтыг 20 удаа зохион байгуулж, 240 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Аймгийн нэгдсэн эмнэлгийн хог хаягдал хариуцсан ажилтанд ажлын байрны дадлага сургалтыг зохион байгуулсан. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент, вакцин биобэлдмэлийг устгах арга зүй сургалтад ЭМТ-үүдийн дархлаажуулалтын хариуцсан сувилагч, бага эмч 19 мэргэжилтнийг хамрууллаа. Халдварт өвчний голомт, нийтийн худалдаа, үйлчилгээний газар, ус хангамжийн байгууллагуудын шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэл, халдваргүйтгэлийг БОАЖС, ХХААХҮС, ЭМС-ын хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралтаар	90

						баталсан химийн бодис хийж байна. 2023 онд 71 байгууллагад 3160 м ² талбайд шавьжгүйтгэл, 13100 м ² талбайд мэрэгчгүйтгэл, 16170 м ² талбайд халдваргүйтгэлийг хийсэн. Химийн бодис, хор өгөөшийн бүртгэл, орлого, зарлагыг тогтмол бүртгэн, тайланг холобгдох байгууллагад хүргүүлэн ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90.0 хувьтай байна.	
1.4	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.4.1	Сүрьеэ, БЗДХ-ын илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн хүн амын хамрагдалтыг нэмэгдүүлнэ	Илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн эзлэх хувь	Зорилтот бүлгийн хүн амын 40 хувийг хамруулсан байна.	Зорилтот бүлгийн хүн амын 80 хувийг хамруулсан байна.	Сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 800 хүн, аймгийн НЭ, Сум, өрхийн ЭМТ-ийн амбулаторийн үзлэгээр 675 хүнд зөвлөгөө заавар өгч ажилласан. Сүрьеэ өвчний ойрын хавьтал 471 хүнийг туберкулины сорил хамруулан, сорилын хэмжилтийг 72 цагийн дараа хийж, сүрьеэ өвчний 3 шинэ тохиолдлыг илрүүлэн эмчлэн эрүүлжүүлж байна. Эрт илрүүлэг үзлэг, “Эрүүл цус-Эрүүл ирээдүй” аян, НЭ-ийн амбулаторийн үзлэгээр БЗДХ-аас сэргийлэх үзлэгт нийт 4091 хүнийг хамруулж, үзлэгээр илэрсэн 73 өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлсэн. Аймгийн НЭ-ийн сайн дурын зөвлөгөө, шинжилгээ өгөх төвөөр 380 хүнд, ЭМБ-уудын цахим хуудсаар 4 төрлийн сурталчилгааны материалыг түгээсэн байна.	100	
1.4.2	Аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг сум, багийн түвшинд зохион байгуулах	Нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдсан иргэдийн тоо	Үзлэгт хамрагдсан иргэдийн тоог 10 хувиар нэмэгдүүлсэн байна.	Үзлэгт хамрагдсан иргэдийн тоог 20 хувиар нэмэгдүүлсэн байна.	Хөдөөгийн хүн амд нийгмийн суурь үйлчилгээг нэг дороос хурдан, шуурхай, чанартай хүргэх зорилгоор "Хүрч үйлчилье" арга хэмжээг 15 сум, 1 тосгонд зохион байгуулж, аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт нийт 24532 иргэн, амны хөндийн үзлэг, оношилгоонд 0-17 насны нийт 14439 хүүхэд буюу нийт хамрагдвал зохих хүүхдийн 76.0 хувийг хамрууллаа. Үзлэг, оношлогоогоор дээд шатлалын эмнэлэгт 51 иргэнийг онош тодруулах, яаралтай эмчилгээний заалтаар шилжүүлсэн байна. Хүүхдийн шүдний цоорлыг эмчлэх 4.4 сая төгрөгний зөөврийн боор машиныг орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийлүүлж, шүдний цооролтой илэрсэн 4530 хүүхэд буюу 31,3 хувийг нь эмчлэн эрүүлжүүлээд байна. “Хүрч үйлчилье” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн даатгалд 515 иргэнийг хамруулан нийт 34,1 сая төгрөгийн орлогыг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн. Хүн амын халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд хамрагдвал зохих иргэдийн	100	

						24423 буюу 41.2 хувийг хамруулсан нь 2022 оны жилийн эцсийн хамрагдалтаас даруй 21.0 хувиар өссөн байна.	
1.4.3	“Эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	50.0 сая	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Хөтөлбөрийн хэрэгжилт 90%	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 100% хэрэгжүүлнэ	<p>Аймгийн ИТХ-ын 2021 оны IV/03 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэнд” хөтөлбөрт 5 зорилтыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж, хөтөлбөрийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.</p> <ul style="list-style-type: none"> Оны эхний 11 сарын статистик мэдээгээр аймгийн хэмжээнд 558 эхээс, 560 амьд нярай мэндэлж, нийт жирэмсэн эхийн 82,9 хувь нь аймгийн НЭ-ийн төрөх тасагт нарийн мэргэжлийн эмчийн хяналтад төрсөн байна. “Умайн хүзүүний хорт хавдар”-ын эрт илрүүлэх “CerviCare” AI оношилгооны аппаратын тусламжтай үзлэг, оношлогоог орон нутагт зохион байгуулж 960 эмэгтэйг хамруулсан үрэвсэлтэй эсийн шинжилгээ өгөх шаардлагатай 100 гаруй эмэгтэй, хавдрын урьдал эдийн шинжилгээ өгөх шаардлагатай 45 эмэгтэйг дээд шатны эмнэлэгт илгээсэн. Жирэмсний эрт үеийн хяналтын хувь 94,8 хувь болж өмнөх оны мөн үеэс 2,0 хувиар нэмэгдсэн нь дэвшүүлсэн зорилтод хүрсэн байна. Энэ оны 11 сарын байдлаар 17-19 насны охидын 21 төрөлт бүртгэгдсэн нь нийт төрөлтийн 3,8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор буурсан байна. “Хүрч үйлчилье” арга хэмжээ, зонхилон тохиолдох үр дүнд хүн амын халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд хамрагдвал зохих иргэдийн 24532 буюу 41.2 хувийг хамруулсан нь 2022 оны жилийн эцсийн хамрагдалтаас даруй 35,7 хувиар өссөн байна. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг төрийн болон ТББ, иргэдийн дунд зохион байгуулан, уулзалт, ярилцлага хэлэлцүүлэгийг 3 удаа, нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд 52, нэрэмжит сарын аян-11 удаа, сургалт сурталчилгааг танхим болон цахимаар 173 удаа зохион байгуулан 10400 иргэдийг хамруулж, сурталчилгаанд давхардсан тоогоор 16431 иргэнийг хамруулсан. Аймгийн хэмжээнд цочмог халдварт өвчний 238 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 38,6 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс тохиолдол 2917 буюу 470,8 промиллоор буурсан байна. Аймгийн хэмжээнд томуу томуу төст өвчний хөдлөл зүйд 7 хоног тутам харуулдан тандаж, эрсдлийн үнэлгээг тогтмол хийж, халдварт өвчний эрт сэрэмжүүлэх хариу арга хэмжээг зохион 	100

						байгуулан ажиллаж байна. Сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэгт 800 хүнийг хамруулан, 471 хүнийг туберкулины сорил хамруулан, сүрьеэ өвчний 3 шинэ тохиолдлыг илрүүлэн эмчлэн эрүүлжүүлж байна. <ul style="list-style-type: none"> Төгсөлтийн дараах мэргэжил эзэмших, дээшүүлэх сургалтад 20 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төрийн сангаар суралцуулж байна. Гадаад сургалтад 9 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Сувиалгчийн мэргэжил эзэмшиж буй 5 сувилагчид орон нутгийн төсвөөс 5,7сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Рашаант Бугат, Бүрэгхангай Орхон сумдын ЗДТГ эмнэлгийн мэргэжилтэн 18 хүний амьдрах байрны түрээс, цахилгаан, дулааны төлбөр, шинээр байшин барихад 8,3 сая төгрөг зарцуулж дэмжлэг үзүүлсэн. <p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төгсөлтийн дараах сургалтын эмч, эмнэлгийн мэргэжилтний байрыг засварлахад ОНХС-ийн 140.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн.</p>	
1.4.4	Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах.	Улсын төсөв	Автомашинаар хангагдсан ЭМБ-ын тоо	Автомашинаар хангагдсан ЭМБ-ын тоо -5	Автомашинаар хангагдах ЭМБ-ын тоо -2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тэшиг, Сайхан сумдын эрүүл мэндийн төвүүд түргэн тусламжийн автомашинаар хангагдсан.	100
1.4.5	Багийн эмч нарыг "Mobile" тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах		"Mobile" тоног төхөөрөмжөөр хангагдсан багийн эмчийн тоо	10 багийн эмч мобайл тоног төхөөрөмжөөр хангагдсан.	12 багийн эмчийг мобайл тоног төхөөрөмжөөр хангана.	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/291 дүгээр тушаалаар Тэшиг, Хутаг-Өндөр, "Эмийн цэцэглэн" ӨЭМТөвүүдийн багийн эмч, их эмч нар тус бүр 1 мобайл тоног төхөөрөмжөөр хангагдсан.	50
1.4.6	Эмч, эмнэлгийн мэргэжилнүүдийг өндөр хөгжилтэй оронд урт болон богино хугацааны сургалтанд хамруулж, туршлага судлуулах		Гадаад орны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэ эс туршлага судалсан, сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	Хилийн чанадад болон цахим сургалтанд нийт 9 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.	Хилийн чанадад болон цахим сургалтанд 10-аас доошгүй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамруулна.	Вьетнам, БНСУ, ОХУ, БНХАУ, Япон улсад "Эмнэлгийн удирдлага менежмент", "Эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ", "Хүүхэд, нярай судлал", "Сувилахуй" чиглэлээр 6 их эмч, 8 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нийт 14 эмнэлгийн мэргэжилтэн гадаад сургалтад хамрагдсан.	100
1.4.7	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг		-Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан сумын тоо	-Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан сумын тоо-0	-Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан сумын тоо-3	Аймгийн хэмжээнд нөхөн үржихүйн насны 14,257 эмэгтэйчүүд байдаг бөгөөд 2023 оны эхний 10 сарын байдлаар 16 суманд зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэгээр 5218 буюу 36,6 хувийг хамруулсан.	90

	урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх		-Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь -Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүлжүүлэлтийн хувь	-Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 60% хувийг хамруулсан. -Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 20%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн байна.	-Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 65 хувийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. -Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 30%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн байна.	Хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт 11509, давхардсан тоогоор нийт 16727 нөхөн үржихүйн насны эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулсан. Энэ нь 15-49 насны эмэгтэйчүүдийн 100 хувийг эзэлж байна. Үзлэгээр хөхний үрэвсэл, умайн хүзүүний улайлт үрэвсэл, хавдрын урьдал, эдийн шинжилгээ өгөх шаардлагатай 241, өндгөвчний уйланхай, умайн гадуурх жирэмслэлт, 16 эмэгтэйг оношлон, эмчийн хяналтад авч, шат дараатай эмчлэн эрүүлжүүлж байна. Лавлагаа шатлалын Эрүүл мэндийн байгууллагуудад 22 эмэгтэйг онош тодруулах, эмчлүүлэхээр шилжүүлсэн.	
1.5	Салбарын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.5.1	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай авахад шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэвийн тасралтгүй байдлыг хангах, хүн амд мэдээллийг шуурхай, үнэн бодит хүргэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх		Нөөцийн бэлэн байдлын хувь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдлын тоо Мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо	Нөөцийн бэлэн байдлыг 82.5 хувийг бүрдүүлэх Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдол гараагүй байх Мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоог нэмэгдүүлсэн байна.	Нөөцийн бэлэн байдлыг 85 хувийг бүрдүүлэх Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдол гараагүй байх Мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоог нэмэгдүүлсэн байна.	Ковид-19 өвчний 15 тохиолдол бүртгэгдэж, нийт өвчлөлийн 6,3 хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн байгууллагууд цахим хаягаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх 12 удаагийн зөвлөмж мэдээллийг иргэд олон нийтэд хүргэсэн. Болзошгүй гамшиг ослоос сэргийлэх дадлага сургуулилалтыг аймгийн ОБГ, бусад салбар нэгжүүдтэй хамтран 2 удаа зохион байгуулж, 140 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамрууллаа. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын 3 сарын нөөцийг бүрдүүлсэн. Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх бэлэн байдлыг 85% хангасан.	100
1.5.2	Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн		Хүүхэд өсвөр үеийнхэнд чиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийг	Хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ	Хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран ЕБС-ийн багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилчдыг хамруулан "Өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар зөвлөн туслах арга зүй" сэдэвт 3 хоногийн цахим сургалтад 21 багш ажилчдыг хамруулсан.	100

	<p>эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол,гэмтлээс сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг ханган ажиллана.</p>		<p>дэмжих арга хэмжээний тоо</p>	<p>үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх нөлөөлийн арга хэмжээг 1 удаа зохион байгуулсан байна.</p>	<p>үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх нөлөөлийн арга хэмжээг 1 удаа зохион байгуулсан байна.</p>	<p>Хүн амд сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах мэдлэг олгох 17 ярилцлага, нөлөөллийн ажлын танилцуулгыг ЭМБ цахим хуудас болон албан ёсны Youtube сувагт байршуулсан. ЕБС-ийн ахлах ангийн 120 сурагчид сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, уур бухимдлаа тайлах, даван туулах арга зүйд суралцуулж, уулзалт, ярилцлага зохион байгууллаа. Эрүүл мэндийн байгууллагуудын хүлээн авах болон амбулатороор үйлчлүүлэгсдэд “Тамхины хор нөлөө”, “Тамхи таны биед хэрхэн муугаар нөлөөлөх нь” зэрэг мэдээллийг өгч, сурталчилгааны материал 240 ширхэгийг тараасан.</p> <p>“Архи, тамхи шинэ үеийнхний сонголт биш” аяны хүрээнд Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн ахлах ангийн 64 сурагчдад “Электрон тамхины хэрэглээний хор уршиг” сэдвээр сургалт зохион байгуулсан. “Эерэг хандлага-Эрүүл ирээдүй” нөлөөллийн арга хэмжээг аймгийн Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар Булган сумын ЕБС-иудтай хамтран зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургууль, Булганхангай МСҮТ, Спортын дунд сургуулийн нийт 300 гаруй сурагч, оюутнууд хамрагдан “Үнэ цэнэ”, “Өсвөрийн үеийнхний эрүүл мэнд”, “Эрсдэлээс өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?”, “Хорт зуршлаас ангид байж чадна” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан.</p>	
1.5.3	<p>Хүүхдийн амын хөндийн эрүүл мэндийг дэмжих, шүд цоорох өвчнийг илрүүлэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах</p>		<p>Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс сэргийлэх сургалтанд хамрагдсан хүүхдийн хувь Шүд цоорох өвчин илрүүлэх үзлэгт хамрагдсан хүүхдийн хувь Шүд цоорох өвчтэй илэрсэн эмчилгээнд хамрагдсан хүүхдийн хувь</p>	<p>Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс сэргийлэх сургалтанд хамрагдсан хүүхдийг 45 хувьд хүргэнэ Шүд цоорох өвчин илрүүлэх үзлэгт хамрагдсан хүүхдийг 45 хувьд хүргэнэ</p>	<p>Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс сэргийлэх сургалтанд хамрагдсан хүүхдийг 90 хувьд хүргэнэ Шүд цоорох өвчин илрүүлэх үзлэгт хамрагдсан хүүхдийг 90 хувьд хүргэнэ Шүд цоорох өвчтэй илэрсэн хүүхдийн</p>	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн амны хөндийн үзлэг, оношлогоог Бүрэгхангай, Орхон, Сайхан, Баян-Агт, Хангал, Хялганат, Хутаг-Өндөр, Тэшиг, Баяннуур, Дашинчилэн, Бугат, Сэлэнгэ зэрэг 12 суманд зохион байгуулж, шүдний эмчийн үзлэгт 5509 иргэнийг хамруулж шүд авах ажилбарыг 70 иргэнд, түрхлэг түрхэх эмчилгээг 129 иргэнд үзүүлсэн байна. • Шүдний нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтний үзлэгийн явуулын багийг суманд 5-7 хоног ажиллуулж, хүн амын амны хөндийг эрүүлжүүлэх зөвлөгөө, зөвлөмжийг иргэдэд хүргэж ажилласан. Үзлэг, оношлогоог Гурванбулаг, Тэшиг сумдад зохион байгуулж 1247 иргэнийг хамруулж, шүд авах ажилбарыг 123, ломбо тавих эмчилгээг 116, түрхлэг түрхэх эмчилгээг 37 иргэнд үзүүлж, 1300 гаруй иргэнд эмчийн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. 	100

				Шүд цоорох өвчтэй илэрсэн хүүхдийн эмчилсэн хувийг 40-д хүргэнэ	эмчилсэн хувийг 80-д хүргэнэ		
1.5.4	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр санаачлагатай ажиллаж, түрээсийн орон сууц, бусад хэлбэрээр орон сууцтай болгох үйл ажиллагааг дэмжиж ажиллана		Орон сууцны дэмжлэг авсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	11 эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар хангагдсан	10-аас доошгүй эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар хангана.	Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Рашаант сумдын удирдлага 4 эмнэлгийн мэргэжилтний амьдрах байрны түрээсийн зардалд 3.1 сая төгрөг зарцуулсан. Орхон, Могод сумын удирдлага 3 их эмчийг орон байраар үнэ төлбөргүй хангасан. Бугат, Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв 7 эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар хангаж, цахилгаан дулааны төлбөрт 4.2 сая төг зарцуулсан. Хутаг-Өндөр сумын удирдлага 1 их эмчид шинээр байшин барихад 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг Дэмжих төвийн 6 өрөөг албан хаагчдын орон сууц болгон ашиглахаар шийдвэрлэж, ОНХС-ийн 140.0 сая төгрөгийг хөрөнгөөр засварын ажил гүйцэтгэх тендер зарлагдсан. Сум орон нутгийн удирдлагаас 18 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллахад орон байрны дэмжлэг үзүүлж, 148.3 сая төгрөг зарцуулаад байна.	100
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
2.1.1	Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ундны ус, ариун цэврийн байгууламжийн төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, нийтийн эзэмшлийн зам, талбайд нус, цэр хаяхгүй байх хөдөлгөөн өрнүүлж ажиллана.		Хуулийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо Зохион байгуулсан аяны тоо	Ус түгээх байранд 48 удаагийн урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийсэн.	Хуулийг сурталчилах 2 арга хэмжээ нийтийн эзэмшлийн зам, талбайд нус, цэр хаяхгүй байх хөдөлгөөн өрнүүлсэн байна.	Булган сумын 6 багийн ус түгээх 14 байранд улирал бүр урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийж, эрүүл ахуйн зөвлөмж мэдээллийг хүргэж ажилласан. Аймгийн хэмжээний 16 сум, 1 тосгоны ус хангамжийн 70 объектоос 140 дээж авч аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторит хими, нян судлал шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээгээр эерэг сорьц илрээгүй. Ус хангамжийн байгууллага, шугам сүлжээнд MNS 0900:2018 стандартын хими бичил амь судлалын үзүүлэлт, хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал, ундны усны эрүүл ахуйн шаардлага чанар аюулгүй байдлын үнэлгээний үзүүлэлтүүд хангагдсан байна.	100
Гурав.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
3.1.1	Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний		-Донорын тоо -Цус цусан бүтээгдэхүүний хангамж, нөөцийн хувь	-Донорын тоо-837 -Цус цусан бүтээгдэхүүний хангамж,	-Донорын тоо-850 -Цус цусан бүтээгдэхүүний хангамж,	Иргэдийн дунд сайн дурын донорын эгнээг өргөжүүлэх ажлыг зохион байгуулснаар одоогийн байдлаар 1502 авлагагүй донор байна. Цус, цусан бүтээгдэхүүний хангамж, нөөц 1000 нэгж буюу 100% байна.	100

	бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх			нөөцийн хувь-100%	нөөцийн хувь-100%		
3.1.2	Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагаа хэрэгжүүлэх		-Сургалтад хамрагдсан ТАХ-ын тоо -Дэмжлэг үзүүлсэн ТАХ-ын тоо, мөнгөн дүн	Сургалтад хамрагдсан ТАХ-ын тоо-1183/давхардсан тоогоор/ -Дэмжлэг үзүүлсэн ТАХ-ын тоо, мөнгөн дүн-22.2 сая төг	Сургалтад хамрагдсан ТАХ-ын тоо-1200 /давхардсан тоогоор/ -Дэмжлэг үзүүлсэн ТАХ-ын тоо, мөнгөн дүн-25.0 сая төг	Салбарын хэмжээнд төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлэн, 36 удаагийн цахим, 62 удаагийн танхимын сургалтад давхардсан тоогоор 1285 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Ариутгал, халдваргүйтгэл, эх барихын чиглэлээр 8 байгууллагын 8 эмнэлгийн мэргэжилтэн ажлын байрны солилцох сургалтад хамрагдсан. БНСУ-д сургалтад хамрагдах 3 эмнэлгийн мэргэжилтэн, БНХАУ-д сурах 2 эмч, сувилагч нарын сургалтын төлбөрт АЗДТГ-аас 11 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн шинээр сувилагч мэргэжлээр суралцах 5 иргэнд аймгийн Засаг дарга 5.7 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн.	100
3.1.3	Архивын улсын үзлэгт хамрагдах		-Улсын үзлэгт хамрагдсан үнэлгээ	-Улсын үзлэгт хамрагдсан үнэлгээ-94%	-Улсын үзлэгт хамрагдсан үнэлгээ-96%	Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын баталсан удирдамжаар "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" сарын аяныг зохион байгуулж, тайлан мэдээг дүгнэх аргачлалаар үнэлж, дүгнэн аймгийн ЗДТГ-ын Төрийн архивын тасагт хүргүүлсэн.	100
3.1.4	Салбарын хэмжээнд санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах		-Тайлан мэдээг хугацаанд үнэн зөв мэдээлсэн байдал -Санхүүгийн зөрчилгүй дүгнэлттэй байгууллагын тоо	-Тайлан мэдээг хугацаанд үнэн зөв мэдээлсэн байдал-95% -Санхүүгийн зөрчилгүй дүгнэлттэй байгууллагын тоо-8	-Тайлан мэдээг хугацаанд үнэн зөв мэдээлсэн байдал-98% -Санхүүгийн зөрчилгүй дүгнэлттэй байгууллагын тоо-10	Эрүүл мэндийн байгууллагуудын хугацаатай тайлан мэдээ ирүүлэлт, үнэн бодит байдалд хяналт хийж, холбогдох зөвлөмжийг тухай бүрт нь өгч ажилласан. Тайлан мэдээ ирүүлэлтийн хувь 98.0 хувьтай байна Байгууллагын "Шилэн данс"-ны байршуулж буй мэдээлэлд хяналт хийхэд Гурванбулаг, Орхон, Хутаг-Өндөр, Сайхан, Хишиг-Өндөр сум мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна. 2022 оны жилийн эцсээр 18 байгууллага санхүүгийн тайлан нэгтгүүлсэн бөгөөд Аудитын газраас 11 байгууллага зөрчилгүй буюу өөрчлөлтгүй , 2 байгууллага хязгаарлалттай, 1 байгууллага сөрөг санал дүгнэлт авсан. 4 байгууллага түүвэрт орсон байна.	100
Дөрөв.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
4.1.1	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, програм хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг		Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, програм хангамжийн дэд	Интернэтийн хурдыг 5мб-ээр нэмэгдүүлсэн. 40.1 сая төгрөгийн үнэ бүхий	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, програм хангамжийг	Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа суурин болон зөөврийн компьютерт шаардлагатай программын шинэчлэлийг тухай бүр нь хийж ажиллаж байна. Сайхан сумын эрүүл мэндийн төвийн 2 интернэтын төхөөрөмж, 216 кабель утсыг шинэчлэн, сүлжээний хэвийн үйл ажиллагааг ханган сайжруулсан	100

	үзүүлж, тасралтгүй байдлыг хангана.		бүтцийг хөгжүүлсэн байх	зөөврийн 20 компьютер болон дагалдах хэрэгслээр хангасан.	сайжруулсан байна.	байна. Нэгдсэн эмнэлгийн сүлжээний серверийг шинэчилж, интернэтийн хурдыг 5мб-аар нэмэгдүүлж, тасралтгүй байдлыг хангасан.	
4.1.2	Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлзүйн "E-Health", "E-Hospital" программ хангамжийн ашиглалтыг сайжруулж тасралтгүй байдлыг хангана.		Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлзүйн "E-Health", "E-Hospital" программ хангамжийн ашиглалтыг сайжруулж тасралтгүй байдлыг хангах	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч нар эмнэлзүйн "E-Health" программ хангамжийг 100% ашиглаж байна.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч нар эмнэлзүйн "E-Health" программ хангамжийг 100% ашиглана.	Аймгийн нэгдсэн эмнэлэгт 97 их эмч эмнэлзүйн E-Health программыг ашиглаж, Улсын хэмжээнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын ашиглагдаж байсан эмнэлзүйн "E-Hospital" системийг Эрүүл мэндийн яамнаас 2023 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс зогсоож, шинээр Health.gov.mn системрүү шилжсэнээр, 61 их эмчид хөнгөлөлттэй эм бичих программын эрх олгоод байна.	100
4.1.3	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах үзүүлэх сургалтыг зохион байгуулах		-Зохион байгуулсан дадлага сургуулийн тоо	2 суманд 2 удаагийн үзүүлэх сургууль зохион байгуулсан.	3 суманд 3 удаа дадлага, сургуулилалт зохион байгуулсан байна.	Газар хөдлөлтийн үеийн стратегийн дадлага, сургуулилалтад аймаг, сумын ЭМБ-уудын 200 гаруй эмч, мэргэжилтнүүд цахимаар оролцлоо. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хохирол багатай даван туулах, чадавхижуулах сургалтад 16 сум, тосгоны 54 багийн эмч нарыг хамруулсан. Болзошгүй гамшиг ослоос сэргийлэх бэлэн байдлын үзлэгт 20 ЭМБ-уудын 356 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж, чадавхжуулсан.	100
4.1.4	Дамжуулагчаар дамжих халдварт өвчний голомтын бүс нутагт тандалт, судалгаа хийх	8,0	-Тандалт, судалгааны тайлан	-Суурь судалгаа хийгдээгүй.	-Судалгаа хийж, тайлан бичигдсэн байна.	Хачигт энцефалитийн голомттой бүс нутагт эрсдэлт хүн амын судалгааг гаргасан. Судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамрагдвал зохих 653 хүн амын 69,4 хувь буюу 453 хүнийг хамруулсан.	70
4.1.5	"Нээлттэй Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэх		Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	"Нээлттэй Булган-2023" арга хэмжээнд дутагдалтай байгаа 64 сул орон тоо, эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах чиглэлээр мэдээлэл бэлтгэн оролцсон. "Нээлттэй Булган" хөтөлбөрийг харьяа байгууллагуудад сурталчлан түгээх ажлуудыг тогтмол зохион байгуулж, хүний нөөцөөр хангах арга хэмжээ авч ажилласнаар 16 байгууллага 48 эмч, эмнэлгийн мэргэжилтнээр хангагдсан байна.	100

Арга хэмжээний хэрэгжилт 100%.

Тав.Хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

5.1.Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1.1	Цахим шилжилт, цахим засаглалыг нэвтрүүлэхэд шуурхай удирдлагаар хангах, эрхлэн гүйцэтгэх	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Тоон гарын үсэг хэрэглэгчдийн тоо	Аймгийн хэмжээнд 500 гаруй төрийн албан хаагч, 1842 иргэн, 16 сумын 325 аж ахуйн нэгж, байгууллагад тоон гарын үсэг олгосон. E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системийг 16 суманд бүрэн нэвтрүүлсэн	Тоон гарын үсэг хэрэглэгчдийн тоог 800-д хүргэх.	Байгууллагын нийт төрийн албан хаагчид тоон гарын үсэг хэрэглэж байна.	100
5.1.2	Вэб сайтын цэс, мэдээллийг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн дагуу боловсруулж оруулах	-	Сайтаа засварласан байгууллагын тоо	2022 онд 15 байгууллага, 8 сум вэб сайтаа шинэчлэн идэвхтэй ажиллуулж байна	16 сум, 23 агентлаг вэб сайтыг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн дагуу засварлаж, мэдээллийг оруулсан байна	Эрүүл мэндийн газрын албан ёсны bu.mohs.gov.mn домайн нэртэй вэб сайтаар иргэдэд хүний нөөцийн ил тод байдал, сул орон тооны зар, авлигын эсрэг хууль, урьдчилан сэргийлэлт, сургалт сурталчилгаа, хууль эрх зүй, тогтоол шийдвэр, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Шилэн дансны тухай хууль, цаг үеийн мэдээ мэдээлэл, видео шиторк, зөвлөмж, анхааруулга, гэсэн 124 удаагийн мэдээ мэдээллийг ил тод тогтмол шинэчилэн хүргэсэн байна. Нийт 30733 иргэний хандалттай байна.. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд тус бүр фэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан мэдээ мэдээллийг ил тод байршуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.	100
5.1.3	Бүх албан хаагчид албаны цахим хаягтай болж, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах	-	Албаны цахим хаяг хэрэглэгч ТАХ-ын тоо	Аймгийн ЗДТГ, Төрийн аудит, СХДАА, СХ зэрэг байгууллагууд албаны	16 сум, 23 агентлагийн албан хаагчид албаны цахим хаягийг хэрэглэж хэвшсэн байна.	Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны 19 албан хаагч, төрийн үйлчилгээний 5 ажилтан албаны цахим хаяг тогтмол ашиглаж хэвшсэн.	100

				цахим хаяг хэрэглэж байна			
5.1.4	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, хэрэгжилтийг улирал тутам тайлагнах	-	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэлтийн хувь	Нийт өргөдлийг ангилвал хүсэлт -3330 / 91.0% , санал-322 /8.0%, гомдол-3 /0.6%, талархал- 2/ 0.4% байна. Газартай холбоотой 976 / 29.0%, мөнгөн тусламж, дэмжлэг, төсөл хөтөлбөрт хамрагдахыг хүссэн 457/ 12.4%, ажил хүссэн 213/6.8%, хэрэглээний модны гоожин хүссэн 181/4.9%, бусад 1830 / 50.0% хувийг эзлээд байна. Аймгийн хэмжээнд мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн 457 иргэн байна. Үүнээс сургалтын	“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлагдсан нээлттэй утас, цахимаар, саналын хайрцаг ажиллуулах журам болон иргэдээс тавьсан асуудалтай холбоотой хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичиг, дүрэм журмыг баримтлан ажиллаж хэвшсэн байна.	2023 оны эхний 11 сарын байдлаар бичгээр 84, байгууллагын “Нээлттэй утас 7034-2455-аар 4, 11-11 төвөөс 0, мэйл хаягаар 0, нийт 88 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс 7 нь гомдол, 81 нь хүсэлт байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100% байна. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. Улирлын мэдээг гаргаж АЗДТГ-ын ХМОНХА-д хүргүүлэн ажилласан. Мөн салбарын үйл ажиллагаа, албан хаагчидтай холбоотой санал, хүсэлт гомдол авах 70342455 дугаар утсыг ажиллуулан, ирүүлсэн санал хүсэлтийг авч, холбогдох журмаар шийдвэрлэж байна. Өргөдлийг агуулгаар нь үзвэл: <ul style="list-style-type: none"> - Сургалтын төлбөрийн дэмжлэг хүссэн 2 иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн. - Мэргэжлийн диплом, гэрчилгээ авах хүсэлт ирүүлсэн 13 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, гэрчилгээг олгосон. - Ажилд орох хүсэлт ирүүлсэн 13 иргэний хүсэлтээс 6 иргэний хүсэлтийг шийдвэрлэн ажилд авч, 7 хүсэлтэд хариу өгсөн. - Сувилахуйн чиглэлээр суралцах хүсэлт ирүүлсэн 9 иргэний хүсэлтийг Глобал удирдагч их сургуультай уулзалт зохион байгуулж шийдвэрлэсэн. - Тэтгэмж хүссэн тухай 34 хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн. - Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой 7 гомдлыг судлан хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн. 	100

				төлбөр болон эмчилгээний зардалд тусламж дэмжлэг хүссэн 21 иргэний өргөдлийг судлан шийдвэрлэж, 14 сая төгрөгийн тусламж, дэмжлэгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс өгч шийдвэрлээд байна.			
5.1.5	Иргэдийн өргөдөл, гомдол, цахимжуулж, хяналт тавих	-	Өргөдөл гомдлыг цахим хэлбэрт оруулах ажлын хувь	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, агентлаг байгууллагын албан ёсны цахим хуудсаар өргөдөл гомдол хүлээж авах цэсийг бий суулгаад байна.	Өргөдөл гомдлыг цахим хэлбэрт оруулах ажлыг 75 хувьд хүргэнэ.	Эрүүл мэндийн газрын вэб сайтад нийт эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт, өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авч байна. Цахимаар 2023 оны эхний 11 сарын байдлаар өргөдөл гомдол ирээгүй болно.	100
5.1.6	Төрийн байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх	-	Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын тоо	2022 оны байдлаар 3783 албан хаагч байгаагаас төрийн захиргааны 532, төрийн	16 сум, 23 агентлаг хүний нөөцийг нэмэгдүүлэх 5 жилийн судалгаа гаргаж төлөвлөгөөний	Салбарын хэмжээнд 781 албан хаагч ажиллаж байгаагаас төрийн захиргааны 21, төрийн үйлчилгээний 760 албан хаагч байна. Эрүүл мэндийн газрын сул орон тооны зарыг ТАЗ-ийн Булган аймаг дахь салбар зөвлөлд 3 удаа хүргүүлж, нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Эрүүл мэндийн	100

			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	үйлчилгээний 3058, бусад ангилалд 193 албан хаагч ажиллаж байна.	биелэлт 30 хувьд хүргэнэ.	газарт 26 төрийн жинхэнэ албан хаагч ажиллахаас одоогийн байдлаар 21 албан хаагч ажиллаж, 5 сул орон тоо байна. Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтаар төрийн жинхэнэ 4 албан хаагч томилогдож, байгууллагын хүний нөөцийн хангалт 81 хувьтай байна. Эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай хүний нөөцөөр хангах 5 жилийн төлөвлөлтийг гаргаж, 19 байгууллагын 71 ажлын байрны сул орон тооны зарыг нэгтгэн холбогдох байгууллагуудад мэдээллийг хүргүүлэн, хүний нөөцөөр хангах арга хэмжээ авч ажилласнаар 16 байгууллага 48 эмч, эмнэлгийн мэргэжилтнээр хангагдсан байна. Салбарын хүний нөөцийн хангалтын хувь 89% байна.	
5.1.7	Төрийн албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэн, чадваржуулах	-	Мэргэшүүлэх багц сургалтад болон боловсролын зэргээ ахиулсан албан хаагчдын тоо	Сум ЗДТГ төрийн албаны тухай хуулийн 55.3 зүйлд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна.	Сургалт нийгмийн баталгааны хөтөлбөрт хөрөнгө тусгах (Төрийн албанд анх томилогдсон болон дунд хугацааны давтан сургалт, ахлах, эрхлэсэн, архив бичиг хэргийн зэрэг нэмэгдүүлэх, мэргэшсэн нягтлан бодогч, магистр, доктор ... гэх мэт)	Удирдлагын академиас зохион байгуулах төрийн албаны мэргэшүүлэх сургалтад хамрагдах төрийн жинхэнэ албан хаагчдын судалгааг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдын сургалтад 3, ахлах түшмэлийн сургалтад 1, дунд хугацааны мэргэшүүлэх давтан сургалтад 1 албан хаагч хамрагдсан. Анагаах ухааны магистрын сургалтад 2 мэргэжилтэн, баклавын сувилагчийн ангид 16 төрийн албан хаагчид төрийн сангийн болон орон нутгийн санхүүжилтээр суралцаж байна.	100
5.1.8	Суманд ажиллаж байгаа эмч, багш болон бусад нарийн мэргэжлийн ажилтнуудад орон сууцны нөхцлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх	-	Орон сууцны нөхцөлөө сайжруулахад дэмжлэг авсан албан хаагчийн тоо	2021 оны байдлаар аймгийн төрийн албан хаагчдыг орон байраар хангахад 57,3 сая төгрөгийн	Орон сууцны нөхцөлөө сайжруулахад 2 албан хаагчид дэмжлэг үзүүлсэн байна. (Суманд ашиглагдаж байгаа болон	Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Рашаант сумдын удирдлага 4 эмнэлгийн мэргэжилтний амьдрах байрны түрээсийн зардалд 3.1 сая төгрөг зарцуулсан. Орхон, Могод сумын удирдлага 3 их эмчийг орон байраар үнэ төлбөргүй хангасан. Бугат, Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв 7 эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар хангаж, цахилгаан дулааны төлбөрт 4.2 сая төг зарцуулсан. Хутаг-Өндөр сумын удирдлага 1 их эмчид шинээр байшин барихад 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг	100

				дэмжлэг үзүүлсэн байна.	ашиглахгүй барилгыг засаж, сайжруулан түрээсийн орон сууц бий болгох)	Дэмжих төвийн 6 өрөөг албан хаагчдын орон сууц болгон ашиглахаар шийдвэрлэж, ОНХС-ийн 140.0 сая төгрөгийг хөрөнгөөр засварын ажил гүйцэтгэх тендер зарлагдсан. Сум орон нутгийн удирдлагаас 18 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллахад орон байрны дэмжлэг үзүүлж, 148.3 сая төгрөг зарцуулаад байна.	
5.2.Хууль, эрх зүйн хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.2.1	Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт амжилттай хамрагдах	Өөрийн хөрөнгө	Улсын үзлэгийн шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэх	Шалгуур үзүүлэлтийг 2019 онд 80-90 хувиар хангасан	Шалгуур үзүүлэлтийг 95 хувиас доошгүй хувиар хангах	Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын баталсан удирдамжаар "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" сарын аяныг зохион байгуулж, тайлан мэдээг дүгнэх аргачлалаар үнэлж, дүгнэн аймгийн ЗДТГ-ын Төрийн архивын тасагт хүргүүлсэн.	100
5.2.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, БНШК байгуулж, ажиллуулах, байгууллагын архивын баримтын тооллого хийх, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг гаргаж хэрэгжүүлэх	Өөрийн хөрөнгө	Зохион байгуулсан сургалт, хяналт шалгалтын тоо, баримт нягтлан шалгах комиссын хурал, тооллогын үр дүн	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн заавар, стандарт, байгууллагын архивын заавар, тооллогын журам шинээр батлагдсан	Хууль, заавар, дүрэм, стандартын хэрэгжилтийг 95 хувьд хүргэх	Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан, байгууллагын даргаар баталгаажуулсан. Мөн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулсан. ЭМГ-ын даргын 2022 оны А/36 тоот тушаалаар БНШК-ыг шинэчлэн томилж, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг шинээр гарган, байгууллагын архивын баримтын тооллого хийлээ. Аймгийн Төрийн архивын Баримт нягтлан шалгах комиссын 2023 оны 03 сарын 10-ны хурлаар хэлэлцүүлж батлуулсны 9 нэр төрлийн 119 баримтыг жагсаалтаар устгасан. Устгалд оруулсан тухай илтгэх хуудсыг аймгийн Төрийн архивын тасагт хүргүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын бичиг хэрэг хариуцсан ажилтнуудтай зүүмээр холбогдож "Баримт бичгийн стандарт, архивын ажлын заавар"-аар сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.	100
5.2.3	"Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн сургалт сурталчилгааг дотооддоо буюу өөрийн ажилтнуудад болон гадагш чиглэсэн хэлбэрээр зохион байгуулах, аймгийн хэмжээнд нэгдсэн	Өөрийн хөрөнгө	Хөтөлбөрийн хэрэгжилтин хувь	Өмнөх онд эрх зүйн сургалт сурталчилгаа хэдэн удаа зохион байгуулсан, хэдэн хүн оролцсон нь	Жилдээ 2 чиглэл тус бүрээр 2-с доошгүй удаа зохион байгуулсан байх Хэдэн удаа, ямар сэдвээр, хэдэн хүн оролцсон нь тодорхой болж	"Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын цахим хуудсаар хууль эрх зүйн зөвлөгөө мэдээллийг иргэдэд тогтмол хүргэн ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын төрийн алба хаагчдад хууль эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран танхим, цахимаар 8 удаа	100

	байдлаар зохион байгуулагдах сургалт семинарт оролцох			тодорхой бус байсан	тайланд тусгагдсан байна.	“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Нийгмийн даатгалын багц хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” зэрэг сэдвээр сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 400 гаран албан хаагчийг хамруулсан байна.	
5.2.4	"Зөв дадал-Архигүй орчин" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллага дээрээ судалгаа гаргаж, сургалт зохион байгуулж, хяналт тавих	Өөрийн хөрөнгө	Хөтөлбөрийн хувь.	Байгууллагын хэмжээнд уг хөтөлбөрт хэрхэн хамрагдаж байгаа нь тодорхойгүй байсан	Байгууллагын хэмжээнд архидан согтуурах, явдал гаргахгүй байх	“Зөв дадал-Архигүй орчин” хөтөлбөрийн хүрээнд байгууллагын төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар, хандлагыг сайжруулах сургалтын төлөвлөгөөг ЭМГ-ын даргаар батлуулан, Цагдаа, Боловсрол, шинжлэх ухааны газар, ОБГ, аймгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, сургалтад давхардсан тоогоор 80 төрийн албан хаагчдыг хамруулсан байна. Цагдаагийн байгууллага, Шүүх, Боловсролын газраас сум, өрхийн ЭМТ-үүдийн дарга, эмч, мэргэжилтнүүдэд 3 удаа сургалт зохион байгуулж, 111 төрийн албан хаагчдыг хамрууллаа.	100
5.2.5	Нийтийн албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулах, хадгалах, хяналт тавих, Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянуулах	Өөрийн хөрөнгө	ХАСУМ-ийг тухай бүр хянуулсан алба хаагчийн тоо, хувь	Холбогдох агентлагаас бусад агентлагийн мэдүүлэг гаргагч нарын бүртгэл судалгаагүй байсан.	ХАСХОМ болон ХАСУМ-тэй холбоотой бүртгэл судалгаатай болж, зөрчил дутагдал гаргаагүй байх.	Салбарын хэмжээнд 2022 оны ХАСХОМ мэдүүлгийг 23 албан тушаалтан гаргасан. 2023 онд шинээр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 4 албан тушаалтны ХАСУМ мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргасан. ХАСХОМ болон ХАСУМ-тай холбоотой зөрчил дутагдал гараагүй болно.	100
5.2.6	Байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтыг сайжруулах, зорилгоор гэрэлтүүлэг, камерын тоо байршлыг нэмэгдүүлэх	Өөрийн хөрөнгө	Нэмэгдсэн гэрэлтүүлэг, камерийн тоо, дотоод хяналтын ажлын хэсгийн төлөвлөгөө	Байгууллага агентлагын ажлын байранд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, тэдгээрийн ажилтны үйлдсэн гэмт хэрэг зөрчлийн судалгаа байхгүй	Нэгдсэн судалгаа, тоо баримт дээр үндэслэн урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах боломжтой болно.	Байгууллагын гадна талын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн, урд тал, хойд талд 2, 1, 2 дугаар давхарт 2 камер нийт 4 камерийг байршуулан, байгууллагын хэвийн ажиллах нөхцлийг хангасан. Байгууллагын гэрэлтүүлэг, камерийг ашигласнаар байгууллагын ойр орчимд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл гараагүй болно.	100
5.3.Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							

5.3.1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Бүх нийтээр мод бут тарих ажилд зохион байгуулалттайгаар оролцох	-	Булган сумын ЗДТГ-аас хуваарилсан тооны мод тарьж, арчлан ургуулна.	-	Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн байх	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн, хавар, намрын мод тариалалтын үеэр Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн нарсан зурваст 2 ш нарс, 75 ш хайлаас, 75 ш бургас мод тарьсан. Мөн байгууллагын 6 албан хаагч өөрсдийн хашаандаа 24 ш (монос, чацаргана, бөөрөлзгөнө, үхрийн нүд, тэхийн шээг, гандигар) тарьсан байна.	100
5.3.2	"Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аянд идэвхитэй оролцож, бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох (зам дагуу хог цэвэрлэгээний ажил, орчны 50 метрийн хог хаягдал, хог ургамал, цас мөсийг арилгах)	-	Зохион байгуулсан нийтийн цэвэрлэгээний ажилд идэвхитэй оролцоно.	-	Хотын өнгө үзэмжийг сайжруулж, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.	"Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аянд идэвхитэй оролцож, нийтийн зам дагуу хог цэвэрлэгээнд 1 удаа, цас цэвэрлэгээнд 1 удаа, орчны цэвэрлэгээнд 3 удаа оролцсон. Байгууллагын орчны 50 м-ийн доторх талбайн хог хаягдал, хог ургамал, цасыг тухай бүрт нь цэвэрлэн ажиллалаа.	100
5.3.3	Байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээнд хэмжих хэрэгсэл суурилуулах	Өөрийн хөрөнгө	Дулааны тоолуурын заалтаар төлбөр төлөх	Дулааны тоолуур байхгүй	Дулааны тоолуур суурилуулсан байна.	Байгууллагад дулааны хэм хэмжих узель байршуулж, Булган Мээж ХХК-ийн тогтоосон үнийн тарифаар сар бүр дулааны төлбөрийг тогтмол хэмжээгээр төлж, 31,8 сая төгрөг зарцуулсан байна.	100
5.3.4	Эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэмнэлт гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх		Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг гаргах	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөгүй	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Байгууллагын эрчим хүчний хэрэглээнд smart тоолуур ашиглаж, хэрэглээг бууруулах арга хэмжээ авч, 2,1 сая төгрөг зарцуулан, өмнөх оноос 0.8 сая төгрөгөөр буурсан байна.	100
5.4. Нийгмийн бодлогын хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.4.1	Хүн бүр эх хэл, соёлоо дээдэлж зөв бичиж хэрэглэж хэвших, байгууллага, хамт олон “Бүх нийтээрээ хос бичигтэн” болоход уриалсан нөлөөллийн ажлуудыг зохион	-	Байгууллагын хаяг, цахим сайт, бичиг хэргийн хөтлөлтийг уйгаржин бичгээр бичиж хэвших, байгууллагын албан хаагчдын монгол хэл, бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг	Монгол хэл бичгийн 16 сургагч багш бэлтгэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд анхан, дунд, ахисан түвшиний сургалтуудыг явуулж 1600-	Төрийн албан хаагчдын унших чадварын ахиц амжилтыг 40 хувьд хүргэх, сургалтуудыг шат дараатайгаар зохион байгуулж 2000 дээш иргэдийг хамруулсан байх	Байгууллагын нийт төрийн албан хаагчдын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-д Монгол бичгийн унших, бичих чадварыг ахиулах зорилт тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын 27 албан хаагч монгол бичгийн чадавхийг дээшлүүлэх богино хугацааны давтан сургалтад хамрагдсан. Албан хаагчдын унших чадварын ахиц өмнөх жилээс 5%-иар дээшилсэн.	100

	байгуулах, сургалтад хамрагдах		мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	1800 хүнийг хамрууллаа. Төрийн албан хаагчдын унших чадварын ахиц амжилтын судалгаагаар тандан судалгаа авахад 32-34% хувьд хүрсэн байна.	/байгууллагын албан хаагчдыг шаталсан сургалтад бүрэн хамруулж, ахиц амжилтыг дээшлүүлсэн байх/		
5.4.2	Хөдөөгийн багийн иргэдэд чиглэсэн хандлагаа өөрчлөх "Хүрч үйлчилье" нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Нийт өрхийн 30-40 хувьд хүрч үйлчилгээ үзүүлэх	Энэ онд нийт 80 багт 95 удаагийн сургалтаар 3020 малчин иргэдэд хүрч ажилласан байна. Энэ нь бүх багт 1-2 удаа 100 хувь хүрч ажилласан байна.	Өрх бүрт хүргэх үйлчилгээг сайжруулсан байх	Аймгийн Засаг даргын захирамжаар зохион байгуулагдсан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэх "Хүрч үйлчилье" арга хэмжээг 15 сум, 1 тосгонд зохион байгуулж, 25161 иргэнийг үзлэг, оношилгоонд хамруулан, эмчийн зөвлөгөө, зааварыг өгч ажилласан. Алслагдсан багийн иргэд, ЕБС-ийн сурагч нарын 5839 хүнд эрүүл мэндээ хамгаалах, дэмжих хандлагаа өөрчлөх нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.	100
5.4.3	"Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох, сорил"-д байгууллагын албан хаагчдыг хамруулах	-	Байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулах	Нийт 40 албан хаагчийг сорил судалгаанд хамруулсан байна.	Нийт 40 албан хаагчийг сорил судалгаанд хамруулсан байна	Бие бялдарын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тодорхойлох сорилд 18 төрийн албан хаагч хамрагдсан. Сорилын дүнгээр ажилтан албан хаагчдын 40 хувь нь бие бялдарын хөгжил хэвийн, 60 хувь дасгал хөдөлгөөнөөр хичээллэх шаардлагатай байна. БТСГ-ын мэргэжилтнүүд өдөр тутам, 7 хоногт хийх дасгал хөдөлгөөн, идэвхитэй хөдөлгөөнийг зааж сургалаа.	100
5.4.4	Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд бүрэн хамруулах	-	Байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулах	Нийт 30 албан хаагчийг эрт ирүүлэгийн үзлэгт хамруулсан.	Нийт 30 албан хаагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна.	Байгууллагын нийт төрийн албан хаагч эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан.	100

Зургаа. 2023 онд шинээр хийж, хэрэгжүүлэх шинэлэг ажил

6.1.1	“Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлах		Эх, хүүхдийн эрүүл мэндийн хяналтын хувь Эхийн ноцтой хүндрэл, хүүхдийн эндэгдлийн түвшин	Жирэмсний эрт үеийн хяналт 92.1 0-5 хүртлэх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин-19.9 Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин-0.9	Жирэмсний эрт үеийн хяналт 95.0 0-5 хүртлэх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин-15.0 Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин-0.0 болгоно	Аймгийн хэмжээнд 2023 оны “Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлаж, эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр төлөвлөгөө гарган ЭМБ-уудад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай. “Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Аймгийн Засаг Даргын санаачлагаар орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 45 сая төгрөгний үнэ бүхий "Умайн хүзүүний хорт хавдар"-ын эрт илрүүлэг, оношилгооны "CerviCare" AI аппаратаар хангасан. Умайн хүзүүний хорт хавдар"-ын эрт илрүүлэг, оношилгооны "CerviCare" AI аппаратын үзлэгийг 8 суманд зохион байгуулж 960 эмэгтэйг хамруулсан үрэвсэлтэй, хавдрын урьдал эдийн шинжилгээ өгөх шаардлагатай 120 эмэгтэй, 5 эмэгтэйг дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлж, хяналтад авч эмчлэн эрүүлжүүлж байна. 2023 оны эхний 10 сарын байдлаар жирэмсний эрт үеийн хяналтын хувь 94.8 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн байна. 2023 онд 10 сарын байдлаар ноцтой хүндрэл 1 тохиолдол бүртгэгдсэн, эхийн эндэгдэлгүй ажиллаж байна. 2023 оны эхний 10 сарын байдлаар 5 хүртлэх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин-24.5, хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин-0.0 байна.	90
-------	--	--	--	---	---	--	----

Нийт хэрэгжилт- 97.2%